

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14 –ний
одрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн
хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хургах журам" –ын
нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	"ХӨВСГӨЛ ХҮНС" ХК
Хаяг:	Хөвсгөл, Мөрөн сум, 8 –р баг, "Хөвсгөл Хүнс" ХК
Хурал хуралдах өдөр, цаг:	2023 оны 04 дүгээр сарын 29–ний өдрийн 17:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 –р баг, "Хөвсгөл Хүнс" ХК –ийн байр, Хурлын танхим
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2024 оны 03 дугаар сарын 20
Олон нийтэд зарлах огноо:	2024 оны 03 дугаар сарын 25
Бүртгэлийн өдөр:	2024 оны 04 дүгээр сарын 14
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2024 оны 03 дугаар сарын 31
Хүргүүлсэн огноо:	
Хурлын даргын нэр:	Л.ДАШЦЭРЭН
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Комиссын дарга: Ж.Алтангэрэл Гишүүд: Б.Дангэвэг Д.Бямбасүрэн
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	
Баримт, бичгийн хуудасны тоо: ширхэг хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

..... /Л.ДАШЦЭРЭН/

2024 оны 03 дугаар сарын 20 –ны өдөр

**ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГА УГСРАЛТ, ХУДАЛДАА
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ “ХӨВСГӨЛ ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 03 –р сарын 20 –ны өдөр

№ 03

Мөрөн хот

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал хуралдуулах тухай*

Хүнс үйлдвэрлэл, барилга угсралт, худалдаа үйлчилгээний “Хөвсгөл Хүнс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэж, олонхийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүнс үйлдвэрлэл, барилга угсралт, худалдаа үйлчилгээний “Хөвсгөл Хүнс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 –р сарын 29–ний өдрийн 17:00 цагт “Хөвсгөл Хүнс” ХК –ийн хурлийн танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - Компанийн 2023 оны жилийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт
 - Компанийн 2023 оны бизнес үйл ажиллагааны тайлан
 - Компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 - ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04–р сарын 14 –ны өдрөөр тогтоосугай.
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2024 оны 03 –р сарын 25 –ны дотор өдөр тутмын 2–с доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээлэх. Энэ мэдээллийг дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
- Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 –р хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02–р хавсралтанд заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 10.00-17:00 цагийн хооронд “Хөвсгөл Хүнс” ХК –ийн байранд ТУЗ –ийн нарийн бичгийн дарга /С.Отгонбаатар/ -с авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

- Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудсын агуулгыг 03 –р хавсралтаар баталсугай.
- Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас” –ыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах брокер, диллерийн компаннар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 5 –с доошгүй хоногийн өмнө байхаар тогтоосугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар ТУЗ –ийн дарга Л.Дашцэрэн, тооллогын комиссын даргаар Ж.Алтангэрэл, гишүүдээр Б.Дашзэвэг, Д.Бямбасүрэн нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ДАШЦЭРЭН

*Төвөлсөн удирдах зөвлөлийн 2024 оны
03 дугаар сарын 20-ны өдрийн
03 дугаар тогтоолын "Хавсралт-01"*



**ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГА УГСРАЛТ, ХУДАЛДАА
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ "ХӨВСГӨЛ ХҮНС" ХК-НИЙ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

1. Хурлын иршийг бүртгэх 17:00-17:30
2. Хурлын иршийг мэдээлэх 5 минут
3. Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах 10 минут
4. Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах 40 минут
5. Хурлын завсарлага 10 минут
6. Тооллогын комисс тогтоолыг танилцуулах 10 минут
7. Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах 20 минут
8. Хурлыг хаах (хурлын дарга) 5 минут

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны
03 дугаар сарын 20 –ны өдрийн
03 дугаар тогтоолын "Хавсралт-02"



**ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГА УГСРАЛТ, ХУДАЛДАА
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ "ХӨВСГӨЛ ХҮНС" ХК-НИЙ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТАНИЛЦАЖ БОЛОХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн 2023 оны жилийн санхүүгийн тайлан түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт
2. Компанийн 2023 оны бизнес үйл ажиллагааны тайлан
3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
4. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардлын төсөн

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны
03 дугаар сарын 20 –ны өдрийн
03 дугаар тогтоолын "Хөвсгөл-03"



**"Хөвсгөл Хүнс" ХКомпанийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хуралд санал авах хуудас**

1. Хурал хуралдах хугацаа: 2024 оны 04 –р сарын 29 –ны 17:00 цагт
2. Хувьцаа эзэмшигчийн овог нэр
3. Эзэмшиж байгаа хувьцааны тоо нирхэг
4. Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар:
5. Харьяалагдах үнэт цаасны компанийн нэр:
6. Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг:

Та шийдвэрийг зөвшөөрч байвал "тийм", татгалзаж байвал "гүй" гэж бичнэ үү

№	Хурлаас гарах шийдвэрийн товч үнэм	Зөвшөөрсөн	Татгалзсан
1	Компанийн 2023 оны жилийн санхүүгийн тайлан, үзүүц хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт		
2	Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан		
3	Компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах		
4	ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөл		

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох чөлөөгүй бол Зуучлагч брокерийн нүүс дээр очиж хурлын материалтай танилцвал санал авах хуудсаар саналаа өгнө.
2. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 70383120, 88119470 утсаар давлаж болно.

Санал авах хуудас хүчингүйд болгосон тухай шалтгаан:.....

**Өдөр тутмын хэвлэлд нэгэн
хувьцаа эзэмшигчийн хурлын тэр**

**"Хөвсгөл Хүнс" ХК-ийн хувьцаа
эзэмшигчдийн анхааралд**

Хүнс үйлдвэрлэл, барилга угсралт, худалдаа үйлчилгээний "Хөвсгөл Хүнс" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 29 -ний өдөр 17:00 цагт "Хөвсгөл Хүнс" ХК-ийн Хурлын танхимд болно.

Хаяг: Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, "Хөвсгөл Хүнс" ХК-ийн байр.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2023.04.14


Хурлаар хэлэлцэх асуудлууд:

- Компанийн 2023 оны жилийн санхүүгийн тайвны, түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт
- Компанийн 2023 оны бизнес үйл ажиллагааны тайлан
- Компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
- ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардлын төсөл

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон хэрэгжих баримт бичигтэй ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд "Хөвсгөл Хүнс" ХК-ийн байранд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /С.Отгонбаатар / - с танилцах боломжтой.

Холбоо барих: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Отгонбаатар

Утас: 88119470



**“ХӨВСГӨЛ ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 03 дугаар сарын 20 –ны өдөр

№ 03

Мөрөн сум

Хурал: 2024 оны 03–р сарын 20 –ны өдөр “Хөвсгөл Хүнс” ХК –ийн гүйцэтгэх захирлын өрөөнд 100 хувийн ирцтэй эхлэв.

Хурал дараах бүрэлдэхүүнтэй болов. Үүнд:

ТУЗ –ийн дарга: Л.Дашцэрэн

ТУЗ –ийн гишүүд: Л.Цэрэнжав, С.Нэргүй, Л.Тэгшбаяр, Л.Тунгалаг,
Л.Төмөрбаатар, Д.Бямбасүрэн, Ж.Сайнжаргал, Ц.Намхай

Хурлаар хэлэлцэх асуудал: “Хөвсгөл Хүнс” ХК –ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай.

Л.Дашцэрэн: “Хөвсгөл Хүнс” ХК –ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах өдөр, цаг, байршлыг хэлэлцэх гэж байгаа тул гишүүд саналаа хэлнэ үү.

Л.Төмөрбаатар: Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуульд хурал хуралдуулах шийдвэр гаргасан өдрөөс хойш 40 –өөс доошгүй хоногийн дотор хуралдуулна гэж заасны дагуу 2024 оны 04 дүгээр сарын 29 –ний өдөр хуралдуулах саналтай байна.

Л.Цэрэнжав : Л.Төмөрбаатар гишүүний саналыг дэмжиж байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 29–ны өдрийн 17:00 цагт “Хөвсгөл Хүнс” ХК –ийн хурлын танхимд хийх саналтай байна.

Л.Дашцэрэн: ТУЗ –ийн бүх гишүүд Л.Төмөрбаатар,Л.Цэрэнжав гишүүдийн саналыг дэмжиж байгаа тул “Хөвсгөл Хүнс” ХК –ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 29 –ны өдрийн 17:00 цагт “Хөвсгөл Хүнс” ХК –ийн хурлын танхимд хийх гэсэн дээр санал хураая.

ТУЗ –ийн гишүүдийн 100 хувийн саналаар “Хөвсгөл Хүнс” ХК –ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 29–ны өдрийн 17:00 цагт Хөвсгөл Хүнс ХК –ийн хурлын танхимд хийхээр тогтлоо.

Иймд Хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 14–ний өдрөөр тогтъя.

Л.Төмөрбаатар: Энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэх саналтай байна. Үүнд:

- Компанийн 2023 оны жилийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт
- Компанийн 2023оны бизнес үйл ажиллагааны тайлан
- Компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
- ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардлын төсвийг батлах

Л.Тунгалаг : Хувьцаа эзэмшигчийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Л.Тэгшбаяр, гишүүдээр ТУЗ -ийн гишүүн С.Отгонбаатар, ТУЗ -ийн гишүүн Д.Бямбасүрэн, Б.Дашзэвэг нарыг оруулах саналтай байна.

Л.Дашцэрэн: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлууд дээр өөр нэмж хэлэлцэх асуудал оруулах гишүүд байвал саналаа хэлнэ үү.

Өөр саналтай гишүүн байхгүй тул энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Л.Цэрэнжавын дэвшүүлсэн асуудлуудыг хэлэлцүүлж гэсэн дээр санал хураая. Гишүүдийн 100 хувийн саналаар дэмжигдлээ.

Санал оруулах гишүүд байна уу?

Өөр саналтай гишүүд байхгүй тул хурлыг хаав.

Шийдвэрлэсэн нь:

- 1 “Хөвсгөл Хүнс” ХК –ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 29 –ны өдрийн 17:00 цагт “Хөвсгөл Хүнс” ХК –ийн хурлын танхимд зарлан хуралдуулах.
- 2 Хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 14 –ны өдөр байхаар тогтов.
- 3 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэхээр болов.
 - Компанийн 2023 оны жилийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн харааг бус Аудитын дүгнэлт
 - Компанийн 2023оны бизнес үйл ажиллагааны тайлан
 - Компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 - ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
- 4 Тооллогын комиссын даргаар Ж.Алтангэрэл, гишүүдээр Д.Бямбасүрэн, Б.Дашзэвэг, нар байхаар дэмжигдлээ.

Хурлын тэмдэгдэл хөтөлсөн:

ТУЗ –ийн нарийн бичгийн дарга /С.Отгонбаатар/

Танилцаж зөвшөөрсөн:

ТУЗ –ийн дарга: /Л.Дашцэрэн/



ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ "ХӨВСГӨЛ ХҮНС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02-р сарын 17-ны өдөр

№ 01

Мөрөн хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Хүнс үйлдвэрлэл, барилга угсралт, худалдаа үйлчилгээний "Хөвсгөл Хүнс" ХК –ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараах эсэх тухай асуудлаар хэлэлцэж, олонхийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүнс үйлдвэрлэл, барилга угсралт, худалдаа үйлчилгээний "Хөвсгөл Хүнс" ХК –ийн ТУЗ -ийн гишүүдийн олонхийн саналыг үндэслэн нэгж хувьцаанд ногдох ашгийг 20 /Хорь/ төгрөг байхаар тогтсугай.
2. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг компанийн гүйцэтгэх захирал /Л.ТӨМӨРБААТАР/ -д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ДАШЦЭРЭН

**“ХӨВСГӨЛ ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 02 дугаар сарын 17 –ны өдөр

№ 01

Мөрөн сум

Хурал: 2024 оны 02 –р сарын 17 –ны өдөр “Хөвсгөл Хүнс” ХК –ийн гүйцэтгэх захирлын өрөөнд 100 хувийн ирцтэй эхлэв.

Хурал дараах бүрэлдэхүүнтэй болов. Үүнд:

ТУЗ –ийн дарга: Л.Дашигэрэн

ТУЗ –ийн гишүүд: Л.Цэрэнжав, С.Нэргүй, Л.Тэгшбаяр, Л.Тунгалаг,
Л.Төмөрбаатар, Д.Ган-Очир, Ц.Намхай, Ж.Сайнжаргал

Хурлаар хэлэлцэх асуудал: “Хөвсгөл Хүнс” ХК –ийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараах тухай.

Л.Дашигэрэн: “Хөвсгөл Хүнс” ХК –ийн нэгж хувьцаанд ногдол ашиг тараах эсэх талаар хэлэлцье.

Л.Төмөрбаатар: “Хөвсгөл Хүнс” ХКомпанийн жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 47,8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Иймд нэгж хувьцаанд 20 төгрөг тараах саналтай байна.

Л.Дашигэрэн: Өөр саналтай гишүүн байхгүй тул санал хураая.
Гишүүдийн 100 хувийн саналаар дэмжигдлээ.

Санал оруулах гишүүд байна уу?

Өөр саналтай гишүүд байхгүй тул хурлыг хаав.

Шийдвэрлэсэн нь:

1. “Хөвсгөл Хүнс” ХК –ийн нэгж хувьцаанд 20 төгрөгийн ногдол ашиг тараах.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ –ийн нарийн бичгийн дарга
/С.Отгонбаатар/

дарга

С.Отгонбаатар

